

Force majeure, Hardship

Гарын авлага

МҮХАҮТанхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр

МҮХАҮТанхимын Хэрэглэгч, үйлчилгээний газар

2020 он

ӨМНӨХ ҮГ

Францын иргэний хуулиас гаралтай, бизнесийн харилцаанд өргөн хэрэглэгддэг **Force Majeure** гэх ойлголтыг Монгол Улсын хууль тогтоомжоор гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал хэмээн нэрлэж, гэрээний үүрэг биелүүлэх боломжгүй хүндэтгэн үзэх үндэслэл буюу зүй ёсны эрсдэл гэх агуулгаар тодорхойлж, энэхүү нөхцөл байдал үүссэн эсэхийг гэрчлэх бүрэн эрхийг олон улсын жишиг ёсоор Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд олгож, хуульчилсан байна.

Давагдашгүй хүчин зүйлийг COVID-19 цар тахлын жишээн дээр тодорхойлбол уг нөхцөл байдал нь 1) **талуудын хүсэл зориг, хяналтаас гадуур болсон** буюу энэхүү цар тахал бий болоход гэрээний аль нэг талын үйлдэл, эс үйлдэл ямарваа нөлөө, оролцоогүй 2) **урьдчилан таамаглах боломжгүй** буюу тахал бий болохыг талууд гэрээ байгуулах үед мэдэх, таах боломжгүй байсан, 3) **урьдчилан сэргийлж, шинжлэн ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй** буюу вакцин гаргаж аваагүй нөхцөл байдал гэсэн үндсэн 3 шинжийг хангасан байна.

Давагдашгүй хүчин зүйлийн ойлголт, агуулга нь гол төлөв иргэн, хуулийн этгээдийн гэрээний шинжтэй харилцаанд чиглэх боловч тухайлсан хууль тогтоомжид заасны дагуу захиргааны шинжтэй үйл ажиллагаанд ч мөн өргөн хэрэглэгддэг. Тухайлбал, газар эзэмших, ашиглах, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахад хугацаа хэтрүүлэх, шүүх, арбитра нэхэмжлэл гаргах, оролцох явцад хуулиар тогтоосон хугацааг хэтрүүлэх зэрэг нөхцөл байдал нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас бий болсон тохиолдолд хүндэтгэн үзэх үндэслэл хэмээн үзэж, тухайн үйлдлийг хийх нөхөн боломж олгохоор хууль тогтоомжид тусгалаа олжээ.

Манай улс ардчилал, чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжсэнээс хойш гучаад жил өнгөрөхөд дотоодын нийт бүтээгдэхүүний 70 орчим хувийг хувийн сектор бүрдүүлж байгаа боловч хөгжингүй орнуудад хэвшил болсон зарим ойлголтыг, тухайлбал *force majeure* буюу давагдашгүй хүчин зүйлийн талаар

бизнес эрхлэгчид тэр бүр мэдэхгүй, ажил хэрэгтээ хангалттай ашиглахгүй байгааг даруй халах шаардлагатай байна.

Энэхүү гарын авлагыг хэвлэн гаргаж буй 2020 онд дэлхий нийтийн нийгэм, эдийн засгийн амьдралд ноцтой хохирол дагуулсан COVID-19 цар тахал гэх давагдашгүй хүчин зүйлийн тод жишээ үргэлжилж, хувь иргэнээс бизнесийн байгууллага, төр улсын түвшинд эмх цэгцтэй, оновчтой бодлого, сахилга бат шаардаж байна. Үүнээс давагдашгүй хүчин зүйл гэдэгт юуг ойлгох тохиолдлыг гэрээнд тоочих уламжлалт байдлаас гадна тухайн тохиолдол нэгэнт бий болсон бол түүний үр дагаврыг хэрхэн зөв зүйтэй арилгах, зохицуулахыг гэрээнд заавал тусгаж байх шаардлагатай нь харагдана.

Таныг бизнесийн эрсдлээ илүү оновчтой тооцоолж, удирдахад энэхүү гарын авлага бага ч болов тус болно гэдэгт найдаж байна.

Энэхүү гарын авлагыг хэвлүүлэн гаргахад туслалцаа үзүүлсэн ЕХ-ны “Монголын худалдааг дэмжих төсөл” /EU-TRAM/-ийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

ХҮНДЭТГЭСЭН,

ДАРГА

Т.ДҮҮРЭН

Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээний гүйцэтгэл нь дайн, эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг зэрэг үйл явдлаас шалтгаалан зогсож болно. Иймд томоохон үнийн дүнтэй гэрээнд тэдгээрийн үр дагаварын талаар тусгах шаардлагатай. Англо-саксоны эрх зүйн системтэй орнуудад ийм байдлыг гэрээг гүйцэтгэх боломжгүй болох буюу “force majeure”, эх газрын эрх зүйн системтэй орнуудад гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэж нэрлэдэг.

Дээрх шалтгаануудын улмаас гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй бол ихэнх улсуудад талууд нь гэрээний гүйцэтгэлийг түр зогсоох, эсвэл бүхэлд нь буюу хэсэгчлэн цуцлах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Ер нь давагдашгүй хүчин зүйлийн аль нэгд автагдсан тал нь тэрхүү үйл явдлыг урьдчилан харах боломжгүй байдаг бөгөөд энэ шинж нь түүнийг давагдашгүй хүчин зүйл гэж үзэх гол үндэс нь болно.

1980 оны Венийн конвенцид давагдашгүй хүчин зүйл, түүний эрх зүйн үр дагавар, хариуцлагаас чөлөөлөгдөх тухай хэм хэмжээ агуулагддаг боловч давагдашгүй хүчин зүйлийн төрөл, хүрээний талаар тусгагдаагүй байдаг. Ундруагаас баталсан олон улсын худалдааны зарчим баримт бичигт давагдашгүй хүчин зүйлийн төрөл, хүрээний талаар тусгагдсан байдаг бөгөөд үүнийг практикт өргөн хэрэглэж байна. Гэхдээ талууд нь давагдашгүй хүчин зүйлийн хүрээ, түүний үр дагавар зэргийн талаар өөрсдийн гэрээнд тусгах нь илүү ашигтай байдаг.

Бизнесийн харилцаа улам бүр өргөжин тэлж, дэлхийн эдийн засгийн бараа эргэлт хурдацтай явагдаж байгаа өнөө үед түүнийг зохицуулах гол механизм болсон гэрээний ач холбогдол асар өндөрт тавигдаж байна. Гэрээгээр харилцаагаа зохицуулна гэдэг нь талуудыг ирээдүйд бий болох болон одоо тохиолдоод байгаа эрсдлээс хамгаалах арга болдог. Тэгэхээр гэрээ гэдэг ойлголт нь талуудын хувьд заавал биелүүлэхээр сайн дураар хүлээсэн үүрэг юм. Иймээс ч гэрээний эрх зүйн үндсэн зарчим нь “*acta sunt servanda*” буюу гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар заавал биелүүлэх зарчим байдаг. Энэ зарчмыг хэрэгжүүлэх явцад талуудад урьдчилан тооцоолох боломжгүй, хүний хүсэл зоригоос гадуур, байгалийн эсвэл нийгмийн нөлөөллөөр гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бэрхшээл тулгарах нь бий. Ялангуяа, бизнес эрхлэгчид гэрээ байгуулах

үед байсан нөхцөл байдал хожим өөрчлөгдөх, гэрээний үүргээ өөрөөс шалтгаалахгүй байдлаар биелүүлэх боломжгүй болох эсэхээ урьдчилан таамаглаж чадахгүй. Практикт гэрээ байгуулах үеийн нөхцөл байдал эрс өөрчлөгдөх тохиолдол гардаг. Богино хугацаанд биелэгдэж, үүргийн харилцаа дуусгавар болох гэрээний тухайд энэ нь ховор тохиолддог ч газар хөдлөлт, халдварт өвчин, гал түймэр, зуд, үер гэх мэт байгалийн шинжтэй, инфляц, эдийн засгийн хэт тогтворгүй өөрчлөлт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэх мэт хэлж ирдэггүй гай гамшгийн хор хөнөөлийг төсөөлөхөд бэрх. Ийм гай гамшиг бизнес эрхлэгчдэд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нөлөөлөх, саад учруулах явдал түгээмэл байдаг. Үүсгэгдэж буй шалтгаан нөхцөлөөр нь үүргийн гүйцэтгэлд саад болох дээрх тохиолдлуудыг дотор нь:

- Force majeure¹ (гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл);
- Hardship² (хүнд нөхцөл байдал) гэж хоёр ангилдаг.

Ийнхүү ангилах нь гэрээний талууд үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал юунаас үүссэнийг тодорхойлоход ач холбогдолтой бөгөөд саад бэрхшээл нь байгалийн уу аль эсвэл нийгмийн хүчин зүйлээс шалтгаалан бий болсон уу гэдгийг тогтоосноор үүрэг гүйцэтгэгч тал үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон нөхцөл байдлаа нотолж гүйцэтгээгүй үүргийн хариуцлагаас чөлөөлөгдөхөд дөхөм болно.

Дэлхийн ихэнх улс орнуудын хууль тогтоомжид гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой нөхцөлүүдийг багтаасан байдаг боловч хүнд нөхцөл байдлын нөхцөлийг тэр бүр зохицуулдаггүй. Эдгээр нөхцөлүүдийг улс орон бүр ялгаатай авч үздэг ба эдгээр нь талуудын шаардлагад нийцэхгүй ч байх тохиолдол

¹ Монгол Улсын Иргэний хуулийн 221 дүгээр зүйлийн 221.2 дахь хэсэгт гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэсэн нэр томъёо хэрэглэсэн тул “force majeure” гэсэн латин нэр томъёог дээрх байдлаар орчуулж ойлгоно. Гэхдээ практикт гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэж ихэвчлэн хэрэглэдэг.

² Хүнд нөхцөл байдал буюу “hardship” нөхцөл гэдэг нь хүндэтгэн үзэх шалтгаантайгаар талууд эдийн засаг, санхүүгийн чадваргүй болох, төлбөрийн чадваргүй болох, гэрээний үүргийг хэрэгжүүлэх нь илт хохиролтой буюу алдагдалтай байх зэргээс болж гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болохыг хэлнэ. Энэ үгийг үндсэн утгаар нь хүнд нөхцөл байдал” гэж орчуулж болох ч бүрэн утга санааг нь илэрхийлэх үүднээс орчуулалгүйгээр хэрэглэсэн нь илүү тохиромжтой.

гардаг. Иймд гэрээний талууд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын тухай гэрээндээ тодорхой тусгах хэрэгтэй юм. Энэ нөхцөлүүдийг гэрээндээ зөв тусгаж чадвал талуудын хооронд үүссэн болон ирээдүйд үүсч болох эрсдэлээс урьдчилан хамгаалж, үүнтэй холбоотой маргааныг эвлэрэх, гэрээний нөхцөлийг дахин өөрчлөх зэрэг хялбар замаар шийдвэрлэх боломжтой юм.

ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ БУЮУ “FORCE MAJEURE” ГЭЖ ЮУ ВЭ?

Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэг нь тухайн гэрээ хэлцэл байгуулах үед урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал үүссэн, эсвэл тухайн нөхцөл байдал талуудын хяналтаас гадуур болсон, түүнийг даван туулах боломжгүй болсон нөхцөл байдал юм. Ихэнх улс орны хууль тогтоомжоор гэрээний үүрэг биелэгдэхгүй болоход нөлөөлөх нөхцөл байдлыг зохицуулсан байдаг бөгөөд үүний сонгодог зарчим нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл буюу “force majeure”-ийн тухай онол юм.

Хэдийгээр ихэнх эрх зүйн системд өөрчлөгдсөн нөхцөл байдлын талаар тусгасан байдаг ч гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн талаар зохицуулалт харилцан адилгүй байдаг.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийг илэрхийлж буй “Force majeure” гэдэг нь үгчлэн орчуулбал бурхны хүсэл зориг гэсэн латин гаралтай үг. Энэхүү нэр томъёо нь орчин үед гэрээний заалт болон түгээмэл хэрэглэгдэж байгаа ба талуудын хяналт, хүсэл зоригоос үл хамаарах (гал, үер, газар хөдлөлт, цас зуд, гэх мэт байгалийн болоод дайн, зэвсэгт бослого, гэмт хэрэг гэх мэт гэрээний үүрэг биелүүлэгч этгээд өөрийн хүсэл зоригоор даван туулах, гэрээний үүргийг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан биелүүлэх боломжгүй үйл явдал тохиолдлууд) нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний үүргээ биелүүлэх боломж, чадваргүй болоход үүнийгээ нотолж чадвал гэрээний үүрэг гүйцэтгээгүй хариуцлагаас чөлөөлөгдөнө. Гэхдээ гэрээний үүргээ биелүүлэхдээ хайхрамжгүй хандан, түүнээс болоод үүрэг биелэгдэх боломжгүй болох эсвэл гэрээний нөгөө талдаа хохирол учруулахаар санаатайгаар үүргийн гүйцэтгэлийг саатуулах, байнга болж байдаг

жирийн байгалийн үзэгдэл (гадаа бороо орж дуустал үүргийн гүйцэтгэл саатах гэх мэт) нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд (force majeure) хамаарахгүй.

Жишээ нь 1: Дархан хотын А компани Улаанбаатар хотын Б компанитай хийн түлш нийлүүлэх гэрээ байгуулжээ. Гэрээ ёсоор нийлүүлэх бараагаа ачин Улаанбаатар хотын зүг явж байсан А компанийн машин аянга цахилгаантай бороотой цаг агаарын нөхцөлд явж байсны улмаас гал гарч улмаар дэлбэрэлт үүсэв. А компани нь түгээлтийн ганц машинтай тул гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлэх боломжгүй болсон байна. Ийм тохиолдолд А компани үүргийн гүйцэтгэлийг хугацаандаа биелүүлээгүйн улмаас хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой. Гэхдээ юун түрүүнд талуудын хооронд байгуулсан гэрээнд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн заалт байгаа эсэхийг анхаарах, байгаа бол түүнд нийцэж буй эсэхийг шалгах ёстой.

Нөгөө талаасаа гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл нь гэрээний үүргийн биелэлтэд нөлөөлөх шинжээсээ хамаараад үүргээс хэсэгчлэн болон бүрэн чөлөөлөх шинжийг агуулсан байж болно. Жишээлбэл, зэвсэгт бослогын үед худалдах, худалдах авах гэрээний дагуу худалдагчийг бараагаа цаг тухайд нь нийлүүлээгүйн хариуцлагаас чөлөөлж болох ч нийлүүлсэн барааны чанарын шаардлага нь гэрээнд зааснаас өөр байсан тохиолдол нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед талуудын хүсэл зоригоос үл шалтгаалан гэрээний үүрэг биелэгдэхгүйд хүрвэл хариуцлагаас хэрхэн чөлөөлөгдөх вэ?

Бизнесийн харилцааг хууль эрх зүйн акт, гэрээгээр урьдчилан харж зохицуулж болдог ч бизнес эрхлэгчид хожим гэрээг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл, байдалтай тулгарах нь цөөнгүй. Тухайлбал, худалдах ёстой барааг тээвэрлэж явсан ачааны машин үерт урсаж бараа уствал үүний улмаас тодорхой хугацаа тогтоосон гэрээний гүйцэтгэл бодитоор хэрэгжих боломжгүй болж болно. Үүнийг гэрээний гүйцэтгэл хууль ёсны дагуу хэрэгжих боломжгүй болсон тохиолдол буюу "Бурхны" үйлдэл, урьдчилан таамаглаж байсан нөхцөл байдал

өөрчлөгдөж, үүрэг үл биелэгдэх болсон буюу гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэж нэрлэдэг. Заримдаа гэрээний гүйцэтгэл биелэгдэх боломжтой байсан ч гэнэтийн үйл явдлууд гэрээний талуудад асар их хохирол учруулдаг. Жишээ нь, газрын түүхий тосыг тогтмол үнээр нийлүүлэх урт хугацааны гэрээний хувьд тосны үнэ хэд хэдэн удаа өссөнөөс болж нийлүүлэгчид болон худалдан авагчдад санхүүгийн хүндрэл учирдаг. Ийм тохиолдолд гэрээт тал гэрээний гүйцэтгэлийг хангаж чадаагүйгээ зөвтгөх шалтгаан болгож гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн заалтыг хэрэглэх гэж оролддог. Мөн өөр нэг жишээ татахад, талууд мод экспортлох гэрээ байгуулан ажиллаж байх явцад аль нэг талын улсын засгийн газраас мод экспортлохыг хориглосон тохиолдолд талуудын хооронд хийсэн гэрээ биелэгдэх боломжгүй болно. Энэ тохиолдолд талууд засгийн газраас ийм тогтоол гаргахыг урьдчилан таамаглах буюу түүнд нөлөөлөх боломжгүй байх тул хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Дээрхээс дүгнэвэл, гэрээний талууд анх гэрээ байгуулахдаа гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн заалтаа оновчтой тусгаснаар тухайн тохиолдол бий болоход үүрэг биелүүлээгүйн хариуцлагаас чөлөөлөгдөх эхний боломж бүрдэнэ. Гэрээний нөхцөл, түүний мөн чанараас шалтгаалаад талууд гэрээндээ гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн заалтаа хэрхэн тусгах нь талуудын гэрээний эрх чөлөөний зарчимтай шууд холбоотой боловч загвар буюу санал болгож байгаа заалтыг гэрээндээ оруулах нь зарим тохиолдолд хялбар байдаг.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд бүх нийтийг хамарсан ажил хаялтаас болж компани татан буугдах хамаарч болох бол таагүй цаг агаар, хүн нас барах, өвдөх зэрэг үйл явдлууд хамаардаггүй. Тиймээс хоёрдугаарт хэрэв аль нэг тал үүргээ биелүүлээгүй нь өөрийнх нь буруутай үйлдэл, эс үйлдлээс болоогүйг нотолж чадвал хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Талуудын хувьд дараах гурван шаардлагыг хангасан тохиолдолд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл тохиолдсон хэмээн үзэж хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл үүссэнд тооцно. Үүнд:

1. Тухайн нөхцөл байдал үүргээ биелүүлээгүй талын хяналтаас гадуур болсон.

2. Гэрээг байгуулах үед тухайн нөхцөл байдлыг таамаглах боломжгүй байсан.
3. Тухайн нөхцөл байдлыг даван туулах боломжгүй байсан.

Хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар ямар зохицуулалт байдаг вэ?

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн талаар улс орон бүрт хуулиар тусгайлан зохицуулсан байдаг. Мөн олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр үүнийг тогтоодог. Манай улсын хувьд Монгол Улсын Иргэний хуулийн 101.7, 220, 221, 255.1, 319.2, 321.3, 352.5.3, 356, 374.3, 384.2, 393.7, 419.2, 427.2, 799.2, 500.2 дугаар зүйлүүдэд гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас үүсэх хариуцлага, үр дагаварын талаар зохицуулсан байдаг. Харин бидний түгээмэл хэрэглэдэг олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдэд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн заалтыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

“Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээ”-ний тухай НҮБ-ын 1980 оны конвенцийн 79 дүгээр зүйлд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

1. Аль нэг тал үүргээ гүйцэтгээгүй нь түүний хяналтаас гадна орших саад бэрхшээлээс болсон бөгөөд гэрээ байгуулах үед уг саад бэрхшээлийг тооцох, түүнээс зайлсхийх буюу түүний үр дагаврыг нь давж гарах арга замыг урьдчилан тооцох аргагүй байсныг дээрх тал тус тус нотолбол тухайн тал үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг хүлээхгүй.
2. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй нь гэрээг бүхэлд нь буюу түүний хэсгийг гүйцэтгүүлэх үүрэг хүлээлгэсэн гуравдагч этгээд уг үүргийг гүйцэтгээгүйгээс шалтгаалсан бол тухайн тал хариуцлагаас зөвхөн дараахь тохиолдолд чөлөөлөгдөнө:
 - а. дээрх хэсгийн заалтын дагуу чөлөөлөгдвөл; түүнчлэн
 - б. дээрх хэсгийн заалтыг хэрэглэх тохиолдолд үүрэг хүлээлгэсэн этгээд хариуцлагаас чөлөөлөгдөж байгаа бол.

3. Хариуцлагаас чөлөөлөх тухай энэ зүйлийн заалт тухайн саад бэрхшээл үргэлжилсэн хугацаанд л хүчин төгөлдөр байна.
4. Үүргээ гүйцэтгэж чадаагүй тал үүрэг гүйцэтгэхэд учирсан саадын тухай, уг саад үүргээ гүйцэтгэхэд нөлөөлж байгаа тухай нөгөө талдаа мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв уг мэдэгдэл нь үүргээ гүйцэтгээгүй тал саадыг мэдсэн буюу мэдэх ёстой байснаас хойш боломжийн хугацаанд нөгөө талд хүрээгүй бол ийнхүү мэдэгдээгүйгээс учирсан хохирлыг уг мэдэгдлийг өгөх ёстой тал хариуцна.
5. Энэ зүйлийн заалт энэхүү конвенцийн дагуу хохирол нөхөн төлүүлэхийг шаардахаас бусад аливаа эрхээ талууд эдлэхэд саад болохгүй.

Мөн олон улсын худалдаанд өргөнөөр хэрэглэгдэж заншсан ЮНИДРОЙТ-оос гаргасан Олон улсын худалдааны гэрээний зарчмуудын 7.1.7-д дараах байдлаар зохицуулсан:

(1) Хэрэв гэрээний үүргээ биелүүлээгүй тал ийнхүү үүргээ биелүүлээгүй нь түүний хяналтаас гадуур болсон бөгөөд гэрээ байгуулах үед урьдчилан таамаглах боломжгүй буюу давж туулах боломжгүй байснаас болсон гэдгийг нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

(2) Гэрээний гүйцэтгэлд саад болж буй нөхцөл байдал түр зуурын байх тохиолдолд зөвхөн энэ хугацааны туршид хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл бий болно.

(3) Гэрээний үүргээ биелүүлээгүй тал гэрээний гүйцэтгэлд саад болж байгаа нөхцөл байдал мөн гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй эсэх тухайгаа нөгөө талдаа мэдэгдэнэ. Хэрэв энэ мэдэгдлийг нөгөө талд зохих хугацаанд өгөөгүй бол гэрээний үүргээ биелүүлээгүй тал ийнхүү мэдэгдэл өгөөгүйгээс үүсэх хохирлыг хариуцна.

(4) Энэ зүйл гэрээг цуцлах, гэрээний гүйцэтгэлийг зогсоох, мөнгөн төлбөрийн хүү шаардах эрхэд хамаарахгүй.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болсноор талуудын гэрээний бусад эрх, үүрэг өөрчлөгдөх үү?

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болж, түүнийг нотолсноор тухайн тал гэрээний үүргээ биелүүлээгүй хариуцлагаас чөлөөлөгдөнө гэсэн үг биш. Учир нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн тохиолдол нь гэрээний үүргийг бүхэлд нь дуусгавар болгохгүй. Зөвхөн уг нөхцөл байдал бий болсноос дуусах хүртэл, дууссаны дараа үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай тогтоосон хугацаа өнгөртөл үүргийн гүйцэтгэл түр хойшлогдож болно. Харин гэрээний үүрэг биелэгдэхгүй байх нь нөгөө талд их хэмжээний хохиролтой байвал гэрээнээс татгалзах бүрэн боломжтой.

Бид та бүхэнд дараах гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн загвар заалтыг санал болгож байна.

“1. Гэрээний аль нэг тал гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй дараах нөхцөл байдал бий болсны улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө. Үүнд: гал түймэр, үер, газар хөдлөлт, салхи шуурга, хар салхи болон байгалийн бусад аюулт үзэгдэл, дайн, халдлага, цэргийн дайралт, үймээн, самуун, цэргийн болон хууль бусаар булаан эзлэх, өмчийг хууль бусаар булаан авах, улсын орлого болгох, террорист үйл ажиллагаа, өмч хөрөнгийг нийгэмчлэх, засгийн газрын хориг арга хэмжээ, хорио цээр, ажил хаялт, цахилгаан эрчим хүчний тасалдал болон телефон холбоо эвдрэх, гэмтэл саатал, тасалдал бий болох зэрэг орно. Уг нөхцөл байдал үүссэн тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий тал гэрээг цуцлах эрхгүй. Гэрээний аль нэг тал дурдсан нөхцөл байдлын улмаас гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болсон гэдгийг нотолж, түүний улмаас учирсан хохирлыг болон тэргүүн ээлжид биелүүлбэл зохих чухал үүргээ аль болох богино хугацаанд биелүүлэхэд шаардлагатай бүх алхмуудыг хийх үүрэгтэй ба гэрээний нөгөө тал гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн гэдэг нь нотлогдож байгаа тохиолдолд нөгөө талдаа гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх хугацаа гаргаж өгөх үүрэгтэй.

2. Гэрээний аль нэг талын МҮХАҮТанхимаас олгосон дээрх нөхцөл байдал үүссэнийг баталсан бичиг баримт нь уг нөхцөл байдал үүссэн болон үргэлжилж буйг нотлох нотолгоо болно.

3. *Хэрэв гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл ... сараас илүү хугацаагаар үргэлжилсэн болон дээрх нөхцөл байдал дууссаны дараа гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх нөгөө талын олгосон нэмэлт хугацаанд үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд аль ч тал нөгөө талдаа мэдэгдэж гэрээг цуцлах эрхтэй.”*

ХҮНД НӨХЦӨЛ БАЙДАЛ БУЮУ “HARDSHIP” ГЭЖ ЮУ ВЭ ?

Бизнесийн харилцаа нь орчин үед нийгэм, эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь болж байна. Тиймээс нийгэм, эдийн засгийн байдал нь бизнест шууд нөлөөлдөг. Улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн урьдчилан таамаглах боломжгүй өөрчлөлт нь гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болгоход гэрээний талуудыг хүргэх нь багагүй тохиолдоно. Энэ үед талууд хүнд нөхцөл байдал буюу “hardship”-ын нөхцөл үүссэн эсэхийг тогтоож, тодорхой алхмуудыг хийснээр урьдчилан таамаглах боломжгүй байсан нийгмийн шинжтэй үүссэн хүнд нөхцөл байдлын улмаас гэрээний аль нэг тал үүргээ биелүүлэх боломжгүй болох, үүргээ биелүүлэх буюу үргэлжлүүлэн биелүүлэх нь илт хохиролтой, алдагдалтай болоход нөгөө талын өмнө үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагаас чөлөөлөгдөж болох юм.

Тодорхойлбол, хүнд нөхцөл байдал буюу “hardship” гэдэгт хууль эрх зүй, улс төр, эдийн засгийн шинжтэй шалтгааны улмаас талууд эдийн засаг, санхүү, төлбөрийн чадваргүй болох, гэрээний үүргээ хэрэгжүүлэхэд илт хохиролтой, алдагдалтай, ашиггүй байх зэргээс болж гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болохыг ойлгоно.

Жишээ 2: Монгол Улсын нэгэн хуулийн этгээд Гүрж Улсын хуулийн этгээдтэй ногоон цай худалдах, худалдан авах тухай гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээ ёсоор Гүржийн тал 2008 оныг дуустал сар бүр тодорхой тооны цайг газраар манай улс руу илгээх үүрэгтэй байв. Гэтэл Гүрж Улс ОХУ-тай дипломат харилцаа гэнэт муудсаны улмаас улс төрийн нөхцөл байдал хүндэрч, эдийн засгийн хямрал бий болов. Үүнээс үүдээд цайны үнэ нэгж тутамд 2 ам.доллараар нэмэгдсэн тул Гүржийн тал гэрээгээр тохиролцсон үнээр бараагаа нийлүүлвэл алдагдал хүлээхээр байна. Энэ тохиолдолд талууд гэрээ байгуулж байх үед урьдчилан

таамаглах боломжгүй, тэдгээрийн хяналт, хүсэл зоригоос гадуур болсон үйл явц гэж үзвэл hardship-ын нөхцлөөр тодорхой хугацаанд гэрээний үүргийн биелэлтийг түдгэлзүүлэх, үүрэг гүйцэтгээгүй хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой.

Хүнд нөхцөл байдлын өөр нэг жишээ бол талуудын байгуулсан гэрээний нөхцөл байдал хууль эрх зүйн орчны өөрчлөлтөөс болоод биелэгдэх боломжгүй болох юм.

Жишээ 3: Монгол улсын иргэн БНСУ-ын иргэнтэй 2006 онд Монгол Улсад хамтарсан компани байгуулах гэрээ байгуулаад БНСУ-ын тал дүрмийн сангийн 51 хувийг, Монголын тал 49 хувийг тус тус бүрдүүлэхээр тохиролцжээ. Ингээд удаан ярилцсаны эцэст 2008 оны сүүлчээр тохиролцсон ёсоор компанийг байгуулах болоход Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хуулинд “гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн өөрийн хөрөнгө нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс дээш, түүний 25-аас доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэнэ” гэж өөрчлөлт орсноор БНСУ-ын тал анх 5100 ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ гэж тооцоолж байснаас 10 дахин их хөрөнгө гаргах хэрэгтэй болжээ. Ийм тохиолдлыг мөн хүнд нөхцөл байдал гэж тайлбарлаж болно.

Жишээ 4: Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг компани жуулчдаас аялалын үнийг урьдчилан авч, гэрээ байгуулан тохиролцсоны дараа төмөр замын байгууллага үнээ гэнэт 50 хувь нэмэгдүүлжээ. Гэтэл жуулчдын гол маршрут нь төмөр замаар аялах байсан бол аяллыг зохион байгуулагч байгууллага алдагдалд орно. Энэ тохиолдлыг мөн хүнд нөхцөл байдал гэж болно.

Хүнд нөхцөл байдал ихэнхдээ гурван бүрэлдэхүүнтэй байна:

1. Тухайн нөхцөл байдал талуудын хяналтаас гадуур болсон;
2. Хүндэтгэн үзэх шинжтэй;
3. Урьдчилан таамаглах боломжгүй.

Хэрэв гэрээ байгуулах үедээ урьдчилан таамаглаж байсан, талууд санаатайгаар тийм нөхцлийг бий болгох боломжтой бол хүнд нөхцөл байдлын заалтад үндэслэн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

Жишээ 5: А компанийн санхүүгийн чадвар буурч алдагдалтай ажиллах болсон ба энэ байдал өөрчлөгдөхгүй бол удахгүй дампуурах нь тодорхой гэдгийг удирдлагууд нь мэдэж байжээ. Гэвч энэ байдлаа мэдсээр байж бусадтай их хэмжээний хэлцэл хийсэн ба гэрээний төлбөрийг урьдчилан авсан байна. Ингээд нөгөө талыг үүргээ биелүүлэхийг шаардахад хүнд нөхцөл байдал үүслээ гэсэн үндэслэлээр үүргийг биелүүлэхээс татгалзжээ. Энэ тохиолдолд хүнд нөхцөл байдал үүссэн гэж үзэх боломжгүй.

Хүнд нөхцөл байдал буюу "hardship" нь гэрээний гол нөхцлийг үндсээр нь өөрчилсөн, аль нэг тал үүргээ биелүүлэхэд зардал их гарах болсон, тухайн гэрээний гүйцэтгэлийн үнэлгээ буурсан, гэрээний үүргийг гүйцэтгэснээр аль нэг тал илтэд их хэмжээний хохирол амсах нь тодорхой байгаа зэрэг нөхцөл байдал гарсан байхыг ойлгоно.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл буюу “force majeure” болон хүнд нөхцөл байдлын буюу “hardship” ялгаа нь юу вэ?

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл ба хүнд нөхцөл байдал нь хоорондоо төсөөтэй ч үүсэн бий болох нөхцөл, үр дагавар зэргээрээ ялгаатай. Хүнд нөхцөл байдал учирснаас аль нэг тал үүргээ бүрэн биелүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байх буюу ийнхүү биелүүлээд ямар ч ашиггүй байх зэрэг үр дагавар гардаг бол гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл тохиолдоход гэрээ биелэгдэх боломжгүй болно. Хүнд нөхцөл байдал тохиолдоход талуудын гэрээ биелүүлэх төлөвлөгөө өөрчлөгдөх болдог бол гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлд гэрээг цуцлах эсвэл хүчингүй болгоно. Товчоор хэлбэл гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл нь илүү бодит үзэгдлээр буюу байгалийн гамшиг, дайн зэргээр илэрдэг бол хүнд нөхцөл байдал нь эдийн засгийн хямрал, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт зэрэг нийгмийн хүчин зүйлээс үүсдэг.

Хүнд нөхцөл байдлын тохиолдлуудад гэрээ байгуулсны дараа түүхий эдийн үнэ өсөх, инфляцийн түвшин өндөр болох, толгой компани дампуурах, аль нэг талын зардал ихсэх, алдагдалтай буюу хохиролтой байх зэрэг нөхцөл байдал байж болно. Хүнд нөхцөл байдал тулгарсан үед ихэнхдээ мөнгөн бус үүрэг гүйцэтгэж байгаа тал хохирч байдаг. Учир нь үүргийн гүйцэтгэлийн улмаас хүнд нөхцөл байдлын тохиолдолд их хэмжээний хохирол амсах магадлалтай болж байгаа юм. Гэвч нөгөө талаасаа хүнд нөхцөл байдлын улмаас аль нэг тал гэрээний үүргээ биелүүлээгүй бол түүнийг нь гэрээний үүргээс бүрэн чөлөөлнө гэж ойлгож болохгүй. Хүнд нөхцөл байдлын тохиолдол бий болсон даруй талууд дахин хэлэлцээ хийж энэ нөхцөл байдлыг хэрхэн даван туулах, шийдвэрлэх талаар харилцан тохиролцох ёстой юм. Практик дээр шүүх, арбитраар хүнд нөхцөл байдлын улмаас гарсан маргааныг шийдвэрлэхдээ гэрээг цуцлахаас илүү гэрээний нөхцлийг өөрчлөх боломжтой эсэхийг нэн тэргүүнд анхаарч үздэг.

Хүнд нөхцөл байдлын гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлээс ялгагдах өөр нэг онцлог нь хэрэв хүнд нөхцөл байдлын тодорхой нөхцөл бий болсны дараа гэрээний үүрэг гүйцэтгэж эхэлсэн эсвэл үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа бол хүнд нөхцөл байдлын зохицуулалтыг хэрэглэж үүргийн гүйцэтгэлийг хойшлуулах, өөрчлөлт оруулах боломжгүй болно. Иймд гэрээний үүрэг гүйцэтгэхээс өмнө хүнд нөхцөл байдлыг хэрэглэх боломжтой. Түүнээс гадна ихэнхдээ урт хугацааны гэрээнд хүнд нөхцөл байдлын заалтыг хэрэглэдэг. Хамгийн гол шаардлага нь талууд хүнд нөхцөл байдлын талаарх нөхцөлийг гэрээндээ заалт болгон оруулсан байх ёстой.

Олон Улсын Худалдааны Танхим (ICC) нь бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалж, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих зорилготой байгууллага болохын хувьд бизнесийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээг төрөлжүүлэн эмхтгэх, уялдуулах, ижилсүүлэх чиглэлээр ихээхэн ажил хийдэг. Эдгээрийн нэг нь 2003 онд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын журмуудыг гаргасан явдал бөгөөд эдгээрийг нэг мөр ойлгоход ихээхэн хувь нэмэр болсон гэж судлаачид дүгнэсэн байдаг.

Олон Улсын Худалдааны Танхимын Гэнэтийн буюу Давагдашгүй Хүчин Зүйлийн Заалт - 2003

1. Гэрээний аль нэг тал дараах зүйлийг нотолж чадвал гэрээний үүргээ биелүүлж чадаагүйгээс бий болох гарах хариуцлагыг хүлээхгүй:
 - a. гэрээний үүргээ биелүүлээгүй нь түүний хараа хяналтаас гадуур саад тотгорын улмаас болсон;
 - b. гэрээг байгуулах үед саад тотгорыг урьдчилан мэдэх боломжгүй байсан;
 - c. саад тотгор, түүний үр дагавраас урьдчилан сэргийлж, даван гарах боломжгүй байсан.
2. Аль нэг тал гэрээний үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх ёстой. Харин гуравдагч этгээдээс болж гүйцэтгэж чадаагүй бол энэ нөхцлийн 4-9 дүгээр заалтын нөхцөл үйлчилнэ:
 - a. Хэрэв гэрээлэгч тал энэ нөхцлийн 1 дэх заалтад заасан шаардлагыг гаргасан бол;
 - b. Хэрэв гэрээлэгч тал гуравдагч этгээдэд адилхан нөхцөл үйлчилнэ гэдгийг нотолсон бол;
3. Талууд хоорондоо өөрөөр тохиролцоогүй бол эсвэл эсэргүүцэх нотлох баримт байхгүй тохиолдолд аль нэг тал энэ нөхцөлийн а ба б зүйлийн хэсгүүдэд дурдсан нөхцөлийг нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

- a. зарласан болон зарлаагүй дайн, зэвсэгт мөргөлдөөн буюу аюултай бослого, гадаадын түрэмгийлэл, гадаадын цэргийн нүүдэл;
 - b. иргэний дайн, бослого, хувьсгал, дээрэм, довтолгоо, иргэний зөрчилдөөн;
 - c. терроризм, далайн дээрэм;
 - d. төрийн албан тушаалтны хууль ба хууль бус үйлдэл, эрх зүйн акт, тушаал, зохицуулалт, захирамж, ажлын байр татан буулгах, эд хөрөнгө дайчлан хураах, нийгэмчлэх;
 - e. халдварт өвчин, тахал, далайн болон хүчтэй шуурга, газар хөдлөлт, хүчтэй давлагаа, аянга цахилгаан, үер, зуд зэрэг байгалийн гамшиг;
 - f. дэлбэрэлт, гал түймэр, машин, үйлдвэр буюу тоног төхөөрөмжийн аль нэг эвдрэх, тээврийн хэрэгсэл удаан хугацаагаар эвдрэх, ажиллахгүй болох, цахилгаан тасрах, харилцаа холбооны хэрэгсэл гэмтэх, эвдрэх;
 - g. бүх төрлийн хязгаар хориг, бослого, зогсолт, удаашрал, хариуцлагаас чөлөөлөгдөх хүсэлтэй талын аж ахуйн нэгжид тохиолдсон ажил зогсолт, ажил хаялт.
4. Энэ нөхцөлийг хэрэглэж байгаа аль нэг тал 6 дахь хэсгийн дагуу гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн талаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдсэн тохиолдолд гэрээний үүргийг биелүүлэх боломжгүй болгосон саад тотгор тохиолдсон үеэс эхэлж, хэрэв гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн тухай мэдэгдлийг нэн даруй мэдэгдээгүй бол нөгөө талд мэдэгдэл очсон үеэс хариуцлагаас чөлөөлөгдөнө.
5. Энэ нөхцөлийг хэрэглэж байгаа тал 6 дахь хэсгийн дагуу гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирол, хариуцлагаас 4 дэх хэсэгт заасан хугацаанаас эхлэн чөлөөлөгдөнө.
6. Саад тотгорын үр дагавар түр зуур байх тохиолдол 4, 5 дахь хэсэгт заасан нөхцөл байдал гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болгосон саад тотгор буюу дурдсан үйл явдлын хүрээнд үйлчилнэ. Энэ нөхцөлийг хэрэглэж байгаа тал нөгөө талдаа саад тотгор буюу дурдсан үйл явдлаас болж гэрээний үүрэг биелэгдэх боломжгүй болсон тухайгаа мэдэгдэх үүрэгтэй.

7. Энэ нөхцөлийг хэрэглэж байгаа тал гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болгосон саад тотгор, үйл явдлын үр дагаврыг багасгах бүхий л арга хэмжээг авна.
8. Энэ нөхцөлийн 1 дүгээр хэсэгт заасан саад тотгорын болон энэ нөхцөлийн 3 дахь хэсэгт дурдсан үйл явдлын хугацаа гэрээний аль нэг тал болон аль аль талд гэрээний үүргээ биелүүлэхэд саад болох гол үндэс болсон тохиолдолд аль нэг тал нөгөө талдаа зохих хугацааны дотор гэрээг цуцлах мэдэгдэл хийж болно.
9. Энэ нөхцөлийн 8 дугаар хэсгийн дагуу болон гэрээний аль нэг тал гэрээг цуцлахаас өмнө гэрээний үүргийн гүйцэтгэлийг хүлээж авсан тохиолдолд нөгөө талдаа уг гүйцэтгэлтэй тэнцэх мөнгөн төлбөрийг төлнө.

ТАЙЛБАР

А. 1 дүгээр зүйл: Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн ерөнхий томъёолол

Тус нөхцөлийн 1 дүгээр зүйлд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн ач холбогдлын тухай ерөнхий томъёололыг ЮНИДРОЙТ-ын Олон улсын арилжааны гэрээний тухай зарчмуудын 7.1.7-р зүйл, Европын гэрээний тухай зарчмуудын 8.108 хэсэг, Олон улсын бараа худалдах худалдан авах гэрээний тухай 1980 оны Венийн конвенцийн 79-р зүйл, 1985 онд Олон Улсын Худалдааны Танхимаас гаргасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн тухай хэсгүүдтэй уялдуулан тайлбарласан. Энэхүү заалтыг үндэслэж гаргасан шалгуур нь тийм ч хатуу шаардлага биш бөгөөд гүйцэтгэх боломжтой учраас 1 (а)-д “хяналтаас гадуур”; 1 (с)-д “давах туулах боломжгүй” гэсэн утгатайгаар тус тус хэрэглэнэ.

Б. 2 дугаар зүйл: Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хамтран гүйцэтгэгч

2 дугаар зүйл 1980 оны Венийн конвенцийн 79.2 зүйл дээр үндэслэн онцгойлон тайлбарласан бөгөөд энэ заалт нь гэрээт талууд үндэслэлээ гаргаж чадвал тодорхой байх болно. Жишээлбэл, гэрээний хамтран гүйцэтгэгч болох С тал үүргээ гүйцэтгээгүйн улмаас А тал В-ын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ

биелүүлээгүй байна. 1980 оны Венийн конвенцийн дагуу А тал гурван үндэслэлээр хариуцлагаас чөлөөлөгдөнө. 1 дүгээр зүйлд зааснаар хоёр тал хоёулаа хамаатай мөн хамтран гүйцэтгэгч С тал ч үүнд хамаатай. А тал С талыг үүргээ гүйцэтгээгүйгээс болж В талын өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж болно. Гэвч энэ нь В талын хувьд илт хохиролтой дэд гэрээлэгч үүргээ гүйцэтгээгүйтэй холбоотой нөхцөлийг 3 дугаар зүйлд оруулаагүй.

В. 3 дугаар зүйл: Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон бусад саад тотгорууд

Тухайн гэрээг дуусгавар болсноос хойш гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн саад тотгорууд энэ заалтад мөн хамаарна. Гэрээний талууд саад гарсан тухайн үед энэ тухай мэдээгүй болон мэдэх боломжгүй байх тохиолдолд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үндэслэлээр хариуцлагаас чөлөөлөгдөхийг хүсдэг. Талууд гэрээ дуусгавар болсноос хойш гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэн гэж үзвэл гэрээнд заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн зүйл, заалтыг баримталж болно. Гэхдээ талууд гэрээний хугацаа дуусах үед мэдээгүй байхад үүссэн саад тотгор энэ заалтад хамаарахгүй байж болох тул үүнийг анхаарах хэрэгтэй юм.

Г. 4 дүгээр зүйл: Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүдийг жагсаавал

3 дугаар зүйлд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нэлээд олон нөхцөлүүд байдаг бөгөөд энэ нь 1 дүгээр зүйлийн энгийн томъёоллыг бодвол илүү нарийвчилсан нөхцөлүүдийг заасан. А тал тус зүйл ангийг хэрэглэснээр гэрээ байгуулах үед түүний хяналтаас гадуур байсан эсвэл даван туулах боломжгүй саад тотгор учирсан гэдгийг нотлох ёстой. Гэхдээ өчүүхэн төдий шалтгаанаар хариуцлагаас чөлөөлөгдөхгүй гэдгийг анхаарах ёстой. Иймд талууд холбогдох нотлох баримтаа гаргах болно. Хариуцлагаас чөлөөлөгдөхийг хүсэж байгаа тал ийнхүү гэрээний үүргээ гүйцэтгээгүй нь давагдашгүй хүчин зүйлсээс болсныг нотлох бол нөгөө тал нь уг нөхцөл байдал хяналтаас гадуур байгаагүй буюу давж туулах боломжтой байсан гэж үзэж байгаагаа нотлоно.

Д. Энэхүү жагсаалтанд орсон тохиолдлууд

3 дугаар зүйлд заасан нөхцлүүд 1985 оны Олон улсын худалдааны танхимын заалтын 2 дугаар зүйлтэй адил юм. Хамгийн гол шинэчлэлт нь 3(с) зүйлд терроризмын тухай багтаасан явдал юм. Эдгээр тохиолдлууд талуудын хяналтаас гадуур буюу урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдлууд юм. Гэхдээ тухайн тал эдгээр нөхцөл байдал түүний хяналтаас гадуур үүссэнээс болж гэрээний үүргээ биелүүлж чадаагүй гэдгээ нотлох хэрэгтэй болно. Талууд “албан тушаалтны захирамж, тогтоол, тушаал” зэрэг нөхцлийг хасах зэргээр дээрх зүйлд жагсаасан тохиолдолд өөрчлөлт хийж болно. Талууд энэ зүйл заалтад жагсаасан тохиолдлыг хасаж эсвэл шинэ зүйл нэмж болно. Гэхдээ хариуцлагаас чөлөөлөгдөхийг хүсэж байгаа тал энэ заалтад жагсаасан нөхцөлөөс өөр тохиолдол гарсан бол 1 дүгээр зүйлд заасан ерөнхий үндэслэлийг баримталж болно. Иймд хариуцлагаас чөлөөлөгдөхийг хүсэж байгаа талын ажилчид үймээн, самуун, бослого гаргаснаас болж гэрээний үүргээ биелүүлж чадаагүй бол 1 дүгээр зүйлд заасан гурван үндэслэлийг нотолсноор хариуцлагаас чөлөөлөгдөж чадна.

Е. Бие даасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл

Олон улсын бараа худалдах, худалдан авах гэрээний тухай 1980 оны Венийн конвенцийн 80 зүйл, ЮНИДРОЙТ-ын Олон улсын арилжааны гэрээний тухай зарчмууд болон Европын гэрээний тухай хуулийн зарчмуудад нэгэнт тусгагдан хариуцлагаас чөлөөлөгдөх тухай зохицуулалтыг энэ зүйлд дахин нуршиж дурдахгүй байхаар ажлын хэсгийнхэн шийдсэн юм. Энэ зүйлийг 1 (а) ба (с) дээрх зохицуулалтыг үндсэндээ өөртөө агуулж байгаа юм.

Ё. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон гэрээний эрх чөлөөний зарчим

Энэ загвар заалтыг талууд гэрээндээ харилцан тохиролцож хийнэ. Талууд энэ заалтад өөрчлөлт оруулах боломжтой. Энэ талаар Тайлбарт дурдсан. Жишээлбэл, талууд 3(d) нөхцөлд зааснаар засгийн газрын тогтоол тушаалаар хориг тавьсан тохиолдолд нийлүүлэгч экспортын зөвшөөрөл авах үүрэгтэй гэж харилцан тохиролцож болно.

Ж. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн ач холбогдол: 4, 5 дугаар зүйл

4, 5 дугаар зүйл гэрээний гүйцэтгэлд саад болж буй нөхцөл байдал үргэлжлэх хугацаанд учирсан хохирлыг арилгах, гэрээний үүргийн биелэлтийг хойшлуулах талаар зохицуулсан.

З. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээ цуцлахтай холбоотой 8, 9 дүгээр зүйл

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал удаан үргэлжилсэн тохиолдолд гэрээний биелэлтийг хойшлуулах болон цуцлах хугацааг тодорхойлох хоёр боломж бий. Үүнд, хамгийн эхэнд тогтмол хугацаа тогтоох, хоёрдугаарт тодорхой бус хугацаа тогтоох боломж юм. Энэ гэрээний загвар заалт хоёр дахь хандлагыг баримтласан. Учир нь бүхий л нөхцөл байдал, арилжаа худалдаанд тогтмол хугацаа тогтооход хүндрэлтэй. Энэ нөхцлийг ЮНИДРОЙТ-ын Олон улсын арилжааны гэрээний тухай зарчмуудын 7.3.1-р зүйл, Европын гэрээний тухай хуулийн 8:103 хэсэг болон Олон улсын бараа худалдах худалдан авах гэрээний тухай 1980 оны Венийн конвенцийн 25 зүйлүүдэд тус тус хэрэглэсэн. Гэхдээ энэхүү тайлбар урьд орхигдсон байсан бол 1(б)-д тодорхой тусгагдсан байна.

И. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон мэдэгдэл

4, 5, 6 болон 8 дугаар зүйлүүдэд мэдэгдэл өгөх асуудлыг зохицуулсан. Энэ зүйлд талуудын мэдэгдэл өгөх журам, хугацаа, ийнхүү мэдэгдэл өгөөгүйгээс үүсэх үр дагаварыг зохицуулсан юм. Энэ зүйл заалтаар талууд хоорондоо мэдэгдэл яаралтай солилцох, ялангуяа хариуцлагаас чөлөөлөгдөхийг хүсэж байгаа тал гэрээний биелэлтэд саад болсон нөхцөл байдлын талаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх асуудлыг зохицуулсан.

Олон Улсын Худалдааны Танхимын Хүнд Нөхцөл Байдлын Заалт - 2003

Хэрэв гэрээ байгуулах үед учирсан үйл явдлыг урьдчилан хамгаалах боломжгүй байсан ч гэрээний талууд гэрээний үүргээ биелүүлэх үүрэгтэй.

Энэ заалтын 1 дэх хэсгийг үл харгалзан аль нэг тал дараах зүйлийг нотолбол энэ заалтыг хэрэглэх боломжит хугацаанд бий болсон нөхцөл байдлын үр дагаварыг зохицуулах үүднээс гэрээний нөхцлийг өөрчлөхөөр хэлэлцэн тохиролцох үүрэгтэй:

- a. тухайн тал гэрээ байгуулах үед урьдчилан таамаглах боломжгүй буюу түүний хяналтаас гадуур үйл явдлаас болж тухайн тал гэрээний үүргээ биелүүлэх ямар ч боломжгүй болсон;
- b. тухайн тал тухайн үйл явдал буюу түүний үр дагаврыг зайлуулах боломжгүй байсан.

Энэ зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэж байгаа ч нөгөө тал дээрх хэсэгт заасны дагуу гэрээний нөхцөлийг өөрчлөхийг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд энэ заалтыг хэрэглэж байгаа тал гэрээг цуцлах эрхтэй.

ТАЙЛБАР

a) ОУХТ хүнд нөхцөл байдлын заалтыг гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн заалтаас тусад нь боловсруулж гаргасан. Энэ нь дараах хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл хүнд нөхцөл байдлыг бодвол түгээмэл тохиолддог. Иймд энэ хоёр тохиолдлыг хамтатган нэг заалтад оруулснаар гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн заалтыг хэрэглэхэд хүндрэл учирч болно. Хоёрдугаарт, энэ хоёр нөхцөл хоорондоо ялгаатай бөгөөд үр дагавар нь ондоо.

b) Энэ зүйлийг оруулах болсон шалтгаан

ОУХТ 1985 онд Хүнд нөхцөл байдлын заалтыг дөрвөн сонголтот зүйл заалттай боловсруулж гаргасан байсан. Энэ удаад нэг томъёололд оруулсан. Энэ зүйл Италийн Иргэний хуулийн 1467 дугаар зүйл, ЮНИДРОЙТ-ын Олон улсын арилжааны гэрээний зарчмуудын 6.2.2-тай ижил төстэй.

c) Талууд үүргээ гүйцэтгэх ёстой.

“Pacta sunt servanda” зарчмын дагуу гэрээний үүргийг заавал биелүүлэх ёстой билээ. 2 дугаар зүйлийн нөхцөл байдал гарсан тохиолдолд 1 дүгээр зүйл заалтыг заавал дагаж мөрдөх албагүй. Гэхдээ “pacta sunt servanda” зарчмын дагуу зөвхөн 2 дугаар зүйлд заасан нөхцөл байдал үүссэнийг анхаарч судална. Иймд 1 дүгээр зүйлд “урьдчилан хамгаалах боломжгүй байсан” (гэрээний үүргээ биелүүлэх ёстой) харин 2 дугаар зүйлд “гэрээний үүргээ биелүүлэх ямар ч боломжгүй болсон” (гэрээний үүргээ биелүүлэхгүй байж болох) гэж томъёолсон.

d) Хүнд нөхцөл байдал ба бий болсон нөхцөл байдал

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн заалтын адил энэ нөхцөлийг талууд гэрээ байгуулсны дараа учирсан саад бэрхшээлийг хамруулж хэрэглэж болно. Гэхдээ гэрээ байгуулах үед бий болсон нөхцөл байдлын талаар талууд мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан тохиолдлыг хүнд нөхцөл байдлын заалтад хамруулж хэрэглэх явдлыг хязгаарласан. Гэрээ байгуулсны дараа бий болсон нөхцөл байдлаас болж гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол хариуцлагаас чөлөөлөгдөх хүсэлттэй тал энэ нөхцөлийг хэрэглэх боломжтой. Гэхдээ гэрээний үүрэг биелүүлэхэд саад болж буй нөхцөл байдал гэрээ байгуулах үед бий болсон байсан бол энэ заалтыг хэрэглэх боломжгүй гэдгийг анхаарах ёстой.

e) Хүнд нөхцөл байдал ба хэлэлцээ хийх үүрэг

Энэ зүйлээр талууд шүүхэд хандахаас өмнө гэрээний үүргийн биелэлтийн талаар хэлэлцээ хийх талаар зохицуулсан. Ингэснээр талууд маргаанаа шийдвэрлэх боломжтой болно. Хүнд нөхцөл байдлын талаарх маргаанаа шийдвэрлэх тусгай зохицуулалт оруулах шаардлагагүй. Хэрэв 3 дугаар зүйлийн дагуу хэлэлцээ хийж чадахгүй, өөрөөр хэлбэл, үүргийн биелэлтийг хүлээж авах тал өөр хувилбар санал болгоогүй бөгөөд үүргээ биелүүлээгүй тал ийм саналыг хүлээн зөвшөөрөхгүй бол гэрээний үүрэг биелүүлээгүй гэсэн үндэслэлээр шүүхэд хандаж болно.

ICC FORCE MAJEURE CLAUSE 2003

1. Unless otherwise agreed in the contract between the parties expressly or impliedly, where a party to a contract fails perform one or more of its contractual duties, the consequences set out in paragraphs 4 to 9 of this Clause will follow if and to the extent that party proves:

- a. that its failure to perform was caused by an impediment beyond its reasonable control; and
- b. that it could not reasonably have been expected to have taken the occurrence of the impediment into account at the time of the conclusion of the contract; and
- c. that it could not reasonably have avoided or overcome the effects of the impediment.

2. Where a contracting party fails to perform one or more of its contractual duties because of default by a third party whom it has engaged to perform the whole or part of the contract, the consequences set out in paragraphs 4 to 9 of this Clause will only apply to the contracting party:

- a. if and to the extent that the contracting party establishes the requirements set out in paragraph 1 of this clause: and
- b. of and to the extent that the contracting party proves that the same requirements apply to the third party.

3. In the absence of proof to the contrary and unless otherwise agreed in the contract between the parties expressly or impliedly, a party invoking this Clause shall be presumed to have established the conditions described in paragraph 1/a/ and /b/ of this Clause in case of the occurrence of one or more of the following impediments:

- a. war /whether declared or not/, armed conflict or the serious threat of same /including but not limited to hostile attack, blockade, military embargo/, hostilities, invasion, act of a foreign enemy, extensive military mobilisation;
- b. civil war, riot rebellion and revolution, military or usurped power, insurrection, civil commotion or disorder, mob violence, act of civil disobedience;

- c. act of terrorism, sabotage or piracy;
- d. act of authority whether lawful or unlawful, compliance with any law or governmental order, rule, regulation or direction, curfew restriction, expropriation, compulsory acquisition, seizure of works, requisition, nationalisation;
- e. act of God, plague, epidemic, natural disaster such as but not limited to violent storm, cyclone, typhoon, hurricane, tornado, blizzard, earthquake, volcanic activity, landslide, tidal wave, tsunami, flood, damage or destruction by lightning, drought;
- f. explosion, fire, destruction of machines, equipment, factories and of any kind of installation, prolonged break-down of transport, telecommunication or electric current;
- g. general labour disturbance such as but not limited to boycott, strike and lock-out, go-slow, occupation of factories and premises.

4. A party successfully invoking this Clause is, subject to paragraph 6 below, relieved from its duty to perform its obligations under the contract from the time at which the impediment causes the failure to perform if notice thereof is given without delay or, if notice thereof is not given without delay, from the time at which notice thereof reaches the other party.

5. A party successfully invoking this Clause is, subject to paragraph 6 below, relieved from any liability in damages or any other contractual remedy for breach of contract from the time indicated in paragraph 4.

6. Where the effect of the impediment or event invoked is temporary, the consequences set out under paragraph 4 and 5 above shall apply only insofar, to the extent that and as long as the impediment or the listed event invoked impedes performance by the party invoking this Clause of its contractual duties. Where this paragraph applies, the party invoking this Clause is under an obligation to notify the other party as soon as the impediment or listed event ceases to impede performance of its contractual duties.

7. A party invoking this Clause is under an obligation to take all reasonable means to limit the effect of the impediment or event invoked upon performance of its contractual duties.

8. Where the duration of the impediment invoked under paragraph 1 of this Clause or of the listed event invoked under paragraph 3 of this Clause has the effect of substantially depriving either or both of the contracting parties of what they were reasonably entitled to expect under the contract, either party has the right to terminate the contract by notification within a reasonable period to the other party.

9. Where paragraph 8 above applies and where either contracting party has, by reason of anything done by another contracting party in the performance of the contract, derived a benefit before the termination of the contract, the party deriving such a benefit shall be under a duty to pay to the other party a sum of money equivalent to the value of such benefit.

ICC HARDSHIP CLAUSE 2003

1. A party to a contract is bound to perform its contractual duties even if events have rendered performance more onerous than could reasonably have been anticipated at the time of the conclusion of the contract.

2. Notwithstanding paragraph 1 of this Clause, where a party to a contract proves that:

[a] the continued performance of its contractual duties has become excessively onerous due to an event beyond its reasonable control which it could not reasonably have been expected to have taken into account at the time of the conclusion of the contract; and that

[b] it could not reasonably have avoided or overcome the event or its consequences, the parties are bound, within a reasonable time of the invocation of this Clause, to negotiate alternative contractual terms which reasonably allow for the consequences of the event.

4. Where paragraph 2 of this Clause applies, but where alternative contractual terms which reasonably allow for the consequences of the event are not agreed by the other party to the contract as provided in that paragraph, the party invoking this Clause is entitled to termination of the contract.

**ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ,
ХҮНД НӨХЦӨЛ БАЙДЛЫН ГЭРЧИЛГЭЭ ГАРГУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХДАА ЮУГ
АНХААРАХ ЁСТОЙ ВЭ?**

Гэрээ, хэлцэл нь эдийн засаг, бизнесийн харилцааг зохицуулах тулгуур хэрэгсэл бөгөөд гүйцэтгэх үндсэн чиг үүрэг нь эрсдэл хуваарилахад оршдог.

Талуудын хараа хяналтаас гадуур, урьдчилан таамаглах боломжгүй бүх төрлийн байгалийн гамшигт үзэгдэл, дайн, зэвсэгт мөргөлдөөн, ажил хаялт, нийтийг хамарсан халдварт өвчин, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл /force majeure/, хүнд нөхцөл байдал /hardship/ нь гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэхэд зайлшгүй магадлах эрсдэл мөн тул манай орны ихэнхи бизнесийн гэрээ, хэлцэлд “Гэнэтийн ба Давагдашгүй хүчин зүйл” гэсэн зүйл, заалт тусгаж, хэвшжээ.

Харин гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдал тэр бүр тохиолдох нь ховор тул иргэн, хуулийн этгээдээс гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын гэрчилгээ гаргуулахаар Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд хандах, зохих ёсоор шийдвэрлүүлэх ойлголт бүрэн тогтож амжаагүй байна.

Иймд бизнес эрхлэгчдэд илүү ойлгомжтой байх үүднээс дараах зөвлөмжийг хүсэлт гаргагчдын гаргадаг нийтлэг алдааг үндэслэн хүргэж байна.

Хүсэлт шийдвэрлэх хугацаа

Иргэн, хуулийн этгээд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын гэрчилгээ гаргуулах хүсэлтээ холбогдох баримтын хамт Монголын

Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд гаргах бөгөөд “Force majeure, Hardship-ийн зөвлөл” нь гэрчилгээ олгох үндэслэл, шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгч, түүний үндсэн дээр гэрчилгээ олгох эсхүл татгалзах хариу өгдөг. Хугацааны хувьд хүсэлтийг холбогдох материалын хамт бүрэн гүйцэд гаргаж өгснөөс хойш энгийн нөхцөлд 30 хүртэл хоногт, яаралтай нөхцөлд 7 хүртэл хоногт тус тус багтаан шийдвэрлэж, холбогдох хариуг бичгээр гаргадаг. Эдгээр хугацааг “хүртэл” хэмээн тодотгосон нь хүсэлт гаргагч баримт, нотолгоогоо бүрэн бүрдүүлж өгсөн эсэхээс шууд хамаарахыг энд онцлох нь зүйтэй. Иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг судалж үзээд нэмэлт материал шаардлагатай тохиолдолд энэ талаар бичгээр мэдэгдэл хүргүүлэх, хариуг ирүүлэх явцад багагүй хугацаа алддаг. Хүсэлт гаргагч өөрийн хүсэлтийг ямар баримт, материал бүрдүүлэн нотлох буюу дэмжих талаар зөвлөгөө авах боломж тус танхимд нээлттэй байдгийг үйлчлүүлэгчид тэр бүр анзаардаггүй.

Гэрээ, хэлцлийн үндсэн дээр үүргийн харилцаа үүссэн байх /гэрээ байгуулсан байх/

Аливаа үүрэг үүсээгүй харилцаанд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын тухай асуудал яригдах боломжгүй тул талууд харилцан үүрэг гүйцэтгэхээр тохиролцон гэрээ, хэлцэл байгуулсан байх шаардлагатай. Ийнхүү үүргийн харилцаа үүссэнийг хүсэлт гаргагч нь батлахын тулд журамд заасны дагуу гэрээг эх хувиар нь эсхүл гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг ирүүлэх шаардлагатай. Ингэхдээ тухайн гэрээ нь хуульд заасан хэлбэрээр байгуулагдсан, хүчин төгөлдөр буюу “гэрээний хугацаа дуусгавар болоогүй” байх шаардлагатай. Гэрээний хугацаа дууссан тохиолдолд хугацааг нь сунгасан, нэмэлт, өөрчлөлт оруулсан гэрээний хувилбарыг давхар ирүүлнэ. Хэрэв тухайн гэрээний эх хувь, нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хүсэлт гаргагчаас гаргах боломжгүй тохиолдолд гэрээний нөгөө талаас тодруулга авах замаар шалгадаг.

Мөн хүсэлт гаргагч нь “гэрээ байгуулсан хугацаа”-гаа нягтлах шаардлагатай. Гэрээ байгуулахад олон шат дараалалтай, тодорхой цаг хугацаа зарцуулагддаг

боловч гэрээ байгуулсан буюу гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл эсхүл хүнд нөхцөл байдал үүссэний дараа байх тохиолдолд гэрчилгээ гаргах боломжгүй болдог. Учир нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт талууд гэрээ байгуулах үед урьдчилан мэдэх, таамаглах боломжгүй нөхцөл байдлыг ойлгодог тул дээрх тохиолдолд талууд эрсдэлийг урьдчилан таамаглах боломжтой байсан гэж үзнэ.

Гэрээнд хамаарах дараагийн нягтлах зүйл нь “үүрэг гүйцэтгэх хугацаа” нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдал үүсэхээс өмнө дуусгавар болоогүй байх шаардлагатай. Жишээ нь бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээр худалдагч нь барааг орон нутагт 2 дугаар сарын 15-ны дотор нийлүүлэх ёстой байсан боловч эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 дугаар сарын 01-ний өдрөөс 30 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоож, хот хоорондын зам тээврийн хөдөлгөөн хаасан бол дээрх шаардлагад нийцсэн гэж үзнэ. Харин дээрх жишээнд дурдсан хорио цээрийн дэглэмийг 2 дугаар сарын 15-наас хойш тогтоосон бол барааг хугацаандаа нийлүүлээгүй тохиолдол нь давагдашгүй хүчин зүйлд үл хамаарна.

Хүсэлт гаргах ба хүсэлт гаргах эрх бүхий этгээд /төлөөлөл/

Иргэн, хуулийн этгээд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын гэрчилгээ гаргуулах хүсэлтдээ үүссэн буюу үүсээд буй нөхцөл байдлыг тодорхой тайлбарлах, уг нөхцөл байдал тохиолдсон болохыг нотлох холбогдох бусад баримтыг хамт ирүүлнэ.

Хувиараа бизнес эрхлэгч хүсэлт гаргаж байгаа бол хүсэлтээ бичгэн хэлбэрт буулгаж, өөрийн гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлагатай.

Харин хуулийн этгээд хүсэлт гаргаж байгаа тохиолдолд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Тухайлбал, энэхүү эрх бүхий этгээд нь хуульд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлага, төрийн бус байгууллагын хувьд удирдах зөвлөлийн дарга байна. Хэрэв хуулиар ийнхүү төлөөлөх эрх олгогдоогүй бол төлөөлөх эрхтэй этгээдийн олгосон итгэмжлэлийн

дагуу хүсэлт гаргана. Ингэхдээ итгэмжлэл нь Иргэний хуулийн 64 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх ёстойг анхаарна уу.

Бусад нотлох баримт

Тухайн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдал бодитой үүсээд буйг хөндлөнгийн, хараат бусаар нотлоход учир шалтгааныг тайлбарласан хүсэлтээс гадна нэмэлт баримт шаардагдах ба уг баримтыг бүрдүүлж, ирүүлэх нь хүсэлт гаргагчийн үүрэг байдаг. Ямар баримт, нотолгоо шаардагдах нь тухайн нөхцөл байдлаас шууд хамааран янз бүр байна. МҮХАҮТ нь хүсэлт гаргагчдаас дараах нийтлэг нэмэлт баримтыг шаардсан байна.

- Тухайлбал, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээр хийж гүйцэтгэсэн үйлдлийг нотлох шаардлага үүсдэг. Жишээлбэл, хүсэлт гаргагч нь лабораторийн тавилга нийлүүлэх гэрээ байгуулсан бол тавилга хийхэд шаардлагатай түүхий эдийг бусдаас худалдан авахаар захиалга өгсөн буюу гэрээ байгуулсан байна. Өөрөөр хэлбэл анхны гэрээний үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л үйлдлийг хийсэн байхыг ойлгоно.

- Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын улмаас зээлийн гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон хүсэлтэд тухайн олох ёстой байсан орлого нь хүсэлт гаргагчийн тухайн жил, сарын орлогод эзлэх хувийг нотлох шаардлагатай. Үүнийг голдуу санхүүгийн тайлан, тооцоо нийлсэн акт, өр, авлагын нэгтгэл зэрэг баримтаар нотолдог. Бизнесийн орлого муудсан болохыг орлогын дүн, санхүүгийн тайланг өмнөх оны мөн үетэй, эсхүл өмнөх саруудтай харьцуулсан байдлаар ирүүлвэл зохилтой.

- Гадаад улсад үүссэн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэрээний үүрэгт нөлөөлсөн тохиолдолд тухайн тохиолдол бий болсон улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимаас олгосон гэрчилгээ, эсхүл эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг нэмэлт баримтаар ирүүлнэ.

- Хууль болон гэрээнд гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл тохиолдсон тухай мэдэгдлийг нөгөө талдаа хүргүүлэхээр заасан бол уг мэдэгдэл г.м

Гэрчилгээний эрх зүйн үр дагавар

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ нь хүндэтгэн үзэх үндэслэлээр гэрээг хугацаанаас өмнө цуцалсантай холбоотой хариуцлагаас чөлөөлөх, гэрээний үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүйтэй холбоотой алданги, торгууль, мөн үүсч болзошгүй хохирол, үр дагаврын хариуцлагаас чөлөөлөх эрх зүйн ач холбогдолтой бол хүнд нөхцөл байдлын гэрчилгээ нь үүсээд буй нөхцөл байдалд нийцүүлэн гэрээний холбогдох нөхцлийг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардах эрх үүсгэж байдгаараа харилцан ялгаатай.

FORCE MAJEURE /ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ/ БОЛОН HARDSHIP /ХҮНД НӨХЦӨЛ БАЙДАЛ/-ЫГ ГЭРЧЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий заалт

- 1.1. Энэхүү журмын зорилго нь гэрээний талуудын хооронд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад талуудын хүсэл зориг, хяналтаас гадуур урьдчилан таамаглах боломжгүй, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал /“гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл” гэх/ болон хүнд нөхцөл байдал бий болсныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас гэрчлэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
Үүнд:
 - 1.2.1. “Force majeure” буюу гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй дараах саад тотгор тохиолдсоны улмаас талууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрэхийг ойлгоно:
 - 1.2.1.1. зарласан болон зарлаагүй дайн, зэвсэгт мөргөлдөөн, бослого, гадаадын түрэмгийлэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, хувьсгал;
 - 1.2.1.2. байгалийн бүх төрлийн гамшиг /хүчтэй салхи шуурга, хар салхи, газар хөдлөлт, хүчтэй давалгаа, үер, цас, зуд, ган гачиг, их хэмжээний бороо, аянга цахилгаан, гал түймэр гэх мэт/;
 - 1.2.1.3. тэсрэлт, дэлбэрэлт, машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, цахилгааны ноцтой гэмтэл;
 - 1.2.1.4. бүх төрлийн хязгаар хориг, өвчин тахал, хорио цээр, хариуцлагаас чөлөөлөгдөх хүсэлтэй талын аж ахуйн нэгжид тохиолдсон ажил зогсолт, ажил хаялт гэх мэт;
 - 1.2.1.5. төрийн албан тушаалтны хуулийн дагуух болон хууль бус үйлдэл, эс үйлдэл, эрх зүйн акт, тушаал, захирамж, ажлын байр татан буугдах, эд хөрөнгө дайчлан хураах, нийгэмчлэх;

- 1.2.2. “Hardship” буюу хүнд нөхцөл байдал гэдэгт хууль эрх зүй, улс төр, эдийн засгийн шинжтэй шалтгааны улмаас талууд эдийн засаг, санхүү, төлбөрийн чадваргүй болох, гэрээний үүргээ хэрэгжүүлэхэд илт хохиролтой, алдагдалтай, ашиггүй байх зэргээс болж гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болохыг;
- 1.2.3. “Гэрчилгээ” гэдэг нь МҮХАҮТанхим тухайн хувь хүн, хуулийн этгээд, байгууллага гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлтэй тулгарсан, хүнд нөхцөлд орсныг гэрчилж, баталгаажуулж байгаа баримт бичгийг;
- 1.2.4. “Хүсэлт гаргагч” гэж гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын гэрчилгээ гаргуулахаар хүсэлт гаргасан гэрээний аль нэг тал болох хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

Хоёр. Гэрчилгээ олгох

- 2.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын гэрчилгээг олгохдоо Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, олон улсын эрх зүйн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, бизнесийн тогтсон заншлын хэм хэмжээ, талуудын хооронд байгуулсан гэрээ болон үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан гаргасан төрийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагын хэм хэмжээ тогтоосон актыг удирдлага болгоно.
- 2.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын гэрчилгээг гаргуулах тухай гэрээний аль нэг талын хүсэлтийг МҮХАҮТ-ын Хэрэглэгч үйлчилгээний газар хүлээн авч, гэрчилгээ олгох үндэслэл, шаардлага хангасан эсэх талаар тус танхимын даргын тушаалаар байгуулагдсан “Force Majeure, Hardship-ийн зөвлөл”-ийн дүгнэлтийг үндэслэн гэрчилгээ олгох эсхүл татгалзах хариуг өгнө.

Хүсэлт гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

 - 2.2.1. тухайн харилцааг зохицуулж буй гэрээндээ гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын заалтыг тусгасан байх;
 - 2.2.2. үндсэн гэрээ болон түүнтэй холбоотой баталгааг гаргахад шаардлагатай баримтуудыг үнэн зөв, бүрэн гаргаж өгөх;
- 2.3. Хэрэв гадаад улсад үүссэн нөхцөл байдлын тухайд баталгаа гаргуулах бол баталгааг үнэн зөв гаргах үүднээс хүсэлт гаргагчаас шаардлагатай материалыг гаргуулна.

2.4. Хэрэв хүсэлт гаргагч нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын заалт гэрээндээ тусгаагүй боловч тухайн тохиолдол нь энэхүү журмын 1.2.1 ба 1.2.2-т дурдсан нөхцөл байдал мөн бол МҮХАҮТанхим нь хүсэлт гаргагчийн хүсэлтийн дагуу холбогдох гэрчилгээг гарган өгч болно.

2.5. Хүсэлт гаргагч нь дараах материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- гэрчилгээ гаргуулах тухай хүсэлт;
- хувь хүн бол иргэний үнэмлэхний хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- энэхүү журмын хавсралтад заасан тарифын дагуу хүсэлтийг судлах үйлчилгээний хураамж төлсөн баримт;
- тухайн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдал тохиолдсон болохыг нотлох холбогдох бусад баримт бичиг.

2.6. Хүндэтгэн үзэх нөхцөл байдлын улмаас гэрээ эх хувиараа эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар хэлбэрээрээ хүсэлт гаргагч талд байхгүй бол тухайн гэрээний хуулбарыг үндэслэн гэрчилгээ гаргаж өгч болох ба ингэхдээ гэрээний нөгөө талаас тодруулга авна.

2.7. Дараах тохиолдолд гэрчилгээ олгохгүй:

- 2.7.1. хүсэлт гаргагчид тохиолдсон үйл явдал, нөхцөл байдал нь талуудын хооронд байгуулагдсан гэрээ, эсхүл энэхүү журамд заасан давагдашгүй хүчин зүйл эсхүл хүнд нөхцөл байдлын тохиолдолд хамаарахгүй;
- 2.7.2. хүсэлт гаргагч шаардлагатай баримт бичиг, мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж өгөөгүй;
- 2.7.3. МҮХАҮТанхимын Force Majeure, Hardship-ийн зөвлөл энэхүү гэрчилгээг гаргах шаардлагагүй гэж үзсэн.

2.8. МҮХАҮТанхим нь Хүсэлт гаргагч уг журмын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт заасан материалыг бүрэн бүрдүүлж өгснөөс хойш энгийн нөхцлөөр 30 хүртэл хоног, яаралтай нөхцөлөөр 7 хүртэл хоногт шийдвэрлэж, холбогдох хариуг бичгээр өгөх ба гэрчилгээг олгох тохиолдолд Хүсэлт гаргагч нь энэхүү журмын хавсралтад заасан тарифын дагуу Гэрчилгээний хураамжийг төлнө.

Гурав. Бусад

3.1. Энэхүү журмыг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3.2. Журамд МҮХАҮТ-ын Даргын тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.

---oOo---